

**АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | | Зорилтот түвшин (2025) | | Шалгуур үзүүлэлтийн тайлбар | Тайлант хугацааны хүрсэн түвшин | Мэдээлэл цуглуулах эх сурвалж | Харилцах байгууллага | Биелэлтийн тайлбар |
|--|---|-------------|--------------|--------|------------------------|--------|--|---------------------------------|-------------------------------|----------------------|--|
| | | | Он | Түвшин | Он | Түвшин | | | | | |
| Нэг. Үндэстний нэгдмэл үнэт зүйл | | | | | | | | | | | |
| Зорилго 1. Эх хэл, түүх соёлыг дээдэлсэн, эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн "Эрдэнэтийн иргэн"-ийг төлөвшүүлнэ. | | | | | | | | | | | |
| Зорилт 1.1. Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч, зөв хүн болгон төлөвших үйл ажиллагааг иргэдийн дунд олон талт хэлбэрээр зохион байгуулна. | | | | | | | | | | | |
| 1 | Иргэдийг эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагаа зохион байгуулсан тоо | тоо | 2020 | - | 2025 | 10 | Жилд 2 арга хэмжээ зохион байгуулна. | 12 | ЗДҮАХ-ийн тайлан | НБХ, БШУГ | "Эх хэл -Эрдэнэт" хөтөлбөр, "Соёлыг түгээе" аяныг жил бүр хэрэгжүүлж давхардсан тоогоор 12 удаа зохион байгууллаа. Эх хэл, уламжлалт зан заншил, түүхээ дээдэлсэн, хотын соёлыг тээгч иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж Жил бүр хүүхдийн цэцэрлэгийн хэмжээнд давхардсан тоогоор 8900 орчим хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд давхардсан тоогоор 26700 орчим хүүхэд хамрагдсан. |
| 2 | Аймгийн нутаг дэвсгэр дэх түүх, соёлын үл хөдлөх дурсгал, соёлын биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ | тоо | 2020 | 11 | 2025 | 20 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг гэрээгээр хамгаалдаг өрхийн тоог 20 болгоно | 20 өрх | - | НБХ, БШУГ | 2022 онд Засаг даргын А/227 дугаар захирамжаар 2 сумдын 20 өрхтэй гэрээ байгуулж нийт 363, 2023 онд дээрх өрхүүдтэй гэрээг сунгаж 28 дурсгалт газрын 343 түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хамгаалалт, аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн бол тус 20 өрхтэй гэрээг сунган Засаг даргын захирамжаар 2024 онд 6.0 сая төгрөг, 2025 онд 8 сая төгрөгийн урамшууллыг олгосон. Мөн түүх соёлын дурсгалт газарт хяналт тавьж ажиллахад 2.0 сая төгрөг зарцуулан ажилласан. |

| | | | | | | | | | | | |
|---|--|-----|------|---|------|--------------------------|---|--------------------------|---------------------|-----------|--|
| 3 | Сургууль, цэцэрлэгүүдийн боловсруулсан үндэсний өв уламжлал, түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээг агуулсан, орон нутгийн онцлогийг таниулсан хичээлийн хөтөлбөрийн тоо | тоо | 2020 | - | 2025 | 10 сургууль, 15 цэцэрлэг | Сургууль, цэцэрлэг өөрийн онцлогт тохирсон сургалтын хөтөлбөр боловсруулна. | 17 сургууль, 31 цэцэрлэг | ЕБС, СӨББ-ын тайлан | НБХ, БШУГ | "Би монгол хүн" сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. "Хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөр", "Монгол бахархлын өдөр", "Эрдэнэт хотын өдөр", "Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээсний баярын өдөр" гэсэн 4 дэд хэсгээс бүрдсэн "Түүхэн тэмдэглэлт өдрүүд" сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн. Цэцэрлэг бүр өөрийн байгууллагын онцлогт тохируулан Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, орон нутаг судлалыг шингээсэн үзэл баримтталыг хэрэгжүүлэн ажилладаг. |
| 4 | Эрдэнэтийн иргэдийн хүртээл болгосон, монголын үндэсний соёлын онцлогийг агуулсан шинэлэг уран бүтээлийн тоо | тоо | 2020 | - | 2025 | 2 | Улсын хэмжээний 2 шилдэг уран бүтээлийг иргэдийн хүртээл болгоно. | 3 | - | НБХ, БШУГ | 2022 онд "Монгол өв соёлоо өвлөн уламжлагчид ба ирээдүйн амжилтын эзэд" бүрэн хэмжээний цахим контент хийгдэж олны хүртээл болсон. 2023 онд "Соёлыг түгээе" аяны хүрээнд "Морин хуурын чуулга"-ын 3 удаагийн тоглолтыг орон нутгийн иргэдийн хүртээл болгосон. 2024 онд аймгийн Хүүхэд залуучуудын театрт "Хөх төрийн бэрс" түүхэн жүжгийг бүтээж иргэдийн хүртээл болгосон. 2025 онд Монгол улсын филармоний "Их найрал", "Сонгодог үдэш" концертыг орон нутгийн иргэдийн хүртээл болгосон ба Хүүхэд залуучуудын театр "Шөнийн хун тайж", "Хөгжилтэй аялал" жүжгүүдийг шинээр туурвин үзэгчдийн хүртээл болгосон. |
| Зорилт 1.2. Байгууллага, иргэдийн дунд үндэсний монгол хэл, бичгээ эзэмших, ашиглах, сурталчлах ажлыг хүртээмжтэй хэлбэрээр зохион байгуулна. | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|--|--|------|------|------|------|-----|--|-------|------------------------|-----------|---|
| 5 | Монгол хэл, бичгийн боловсролыг сурагчдад эзэмшүүлэх арга технологийн сайжруулалт, суралцах таатай орчин бүрдүүлэлт, сургалтын чанар | хувь | 2020 | 45.3 | 2025 | 52 | Бага, дунд, ахлах ангийн Монгол хэл, бичгийн хичээлийн чанарын үнэлгээний дунджийг ахиулна. /улсын дундаж 45.8/ | 80.2% | Оношлох үнэлгээний дүн | НБХ, БШУГ | Монгол хэл, бичгийн хичээлийн чанарын үнэлгээ 2022 оноос хойш хийгдээгүй. Ерөнхий боловсролын сургуулиудын монгол хэл бичгийн хичээлийн улсын шалгалтын дундаж 80.2% - тай байгаа ба дунджаас дээгүүр 13 сургууль, дунджаас доогуур 7 сургууль байна. Монгол хэл, бичгийн шалгалтад хамрагдсан 10 дугаар ангийн 1071 сурагчийн хэмжээст онооны аймгийн дундаж 515.2, 11 дүгээр ангийн 1534 сурагчийн хэмжээст онооны дундаж 443.6, 12 дугаар ангийн 1472 сурагчийн хэмжээст онооны дундаж 543.9 ба өмнөх онтой харьцуулахад босго оноо аваагүй сурагчийн тоо 50%-аар буурсан байна. |
| 6 | Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх "Эх хэл-Эрдэнэт" төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2020 | - | 2025 | 100 | Хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувьд хүрч байгууллага, иргэдийн дунд үндэсний монгол хэл, бичгээ эзэмших, ашиглах хөдөлгөөн өрнүүлнэ. | 100% | Хөтөлбөрийн тайлан | НБХ, БШУГ | Аймгийн ИТХ-ын 2021 оны 04 дүгээр тогтоолоор "Эх хэл-Эрдэнэт" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилт 96.0 хувьтай байна. Тайлант хугацаанд 47 байгууллагын 800 гаруй албан хаагч анхан дунд, ахисан шатны сургалтад хамрагдаж, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаанд нийт 3200 гаруй иргэд, олон нийт, хүүхдүүд оролцсон. Төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудсыг 100% хос бичигт шилжүүлсэн. |
| Зорилт 1.3. Иргэд, хүүхэд, залуучуудыг нийгмийн ёс зүйг дээдэлдэг, өөрийн хотын үнэт зүйлсээр бахархдаг, эерэг харилцаа, хандлага бүхий ухамсарт зан үйлд суралцуулна. | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|------|------|------|------|----|---|-------|--------------------------------------|-----------|--|
| 7 | Иргэдийн аж төрөх байдалд нөлөөлөхүйц "Хотын соёл-Хамтын соёл" гэх мэт нийгмийн ёс зүйг дээдлэх, харилцаа хандлагад эерэг өөрчлөлт гаргахуйц олон талт ажил | тоо | 2020 | 2 | 2025 | 10 | Жилд 2-с доошгүй арга хэмжээнд дэмжлэг үзүүлж зохион байгуулна. | 10 | ЗДҮАХ-ийн тайлан | НБХ, БШУГ | Нийгмийн амьдралд "Хотын соёл-Хамтын соёл"-ын хэм хэмжээг төлөвшүүлэх, бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлж, иргэдийг соён гэгээрүүлэх зорилгоор "Соёлыг түгээе" аяныг 2021-2025 онуудад 5 удаа зохион байгуулсан. Мөн 2022 онд "Сошиал орчинд соёлтой байцаага" цахим нөлөөллийн үйл ажиллагаа, хэлэлцүүлэг зохион байгуулсан. 2022 оноос эхлэн 12-р сарын 11-ний өдрийг Эрдэнэт хотын өдөр болгон тэмдэглэхээр шийдвэрлэн, жил бүр урлаг, соёлын олон үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. Уг аяны хүрээнд 33 төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд байгууллага дээрээ тусгай төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу байгууллагын соёл, иргэдэд үзүүлэх үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар бодитой ажлыг зохион байгуулж, хэвшүүлэн, цахим орчинд олон нийтэд сурталчлан ажилласан. |
| 8 | Монгол хүний амин /давуу/ чанарыг эрхэмлэж, үндэсний ёс заншил, уламжлалыг түгээх | тоо | 2020 | 1 | 2025 | 5 | Хэрэгжүүлсэн зорилтот үйл ажиллагааны тоо | 5 | ЗДҮАХ-ийн тайлан | НБХ, БШУГ | МҮОНТ-ийн "Өв соёл" 2 цуврал нэвтрүүлэгт аймгийн "Соёлын биет бус өв тээгчид"-ийг оролцуулж сурталчилсан. Мөн 2024-2025 онд угийн бичиг хөтлөх арга зүйн 16 удаагийн сургалт, цус ойртолтоос сэргийлэх 2 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Эдгээрт давхардсан тоогоор 30000 гаруй иргэд хамрагдсан. Мөн ерөнхий боловсролын сургуулиудад "Би монгол хүн" сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн. |
| Хоёр. Эрүүл, бүтээлч, хөгжих тэмүүлэлтэй-Эрдэнэт хүн | | | | | | | | | | | |
| Зорилго 2.Гэр бүлд ээлтэй, хүний хөгжилд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, оюунлаг, ёс суртахуунтай, байнгын орлоготой, дэлхийд үнэлэгдэх "Эрдэнэтийн иргэн" төлөвшүүлнэ. | | | | | | | | | | | |
| Зорилт 2.1. Боловсролын үйлчилгээг тэгш, чанартай зохион байгуулж, хүртээмжийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 9 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт, чанар, хүртээмж | хувь | 2020 | 91.1 | 2025 | 94 | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт | 98.9% | Боловсролын салбарын статистик мэдээ | НБХ, БШУГ | 2025-2026 оны хичээлийн жилд аймгийн хэмжээнд 38 цэцэрлэгт 8591 хүүхэд суралцаж байна. Бүлэг дүүргэлт 27.9, хамран сургалт 98.9%-тай байна. Хүүхдийн цэцэрлэгт суралцаж буй хүүхдийн тоо өмнөх оныхоос 316-аар буурч, бүлгийн тоо 2 оор нэмэгдсэн. |

| | | | | | | | | | | | |
|--|--|------|------|------|------|-------------------------|--|-------|--------------------------------------|-----------|---|
| 10 | “Багш” төсөл, хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангах хувь | хувь | 2020 | 92.1 | 2025 | 95 | Багш нарын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэн, нийгмийн баталгааг хангах ажлуудыг хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ. | 97.8% | Хөтөлбөрийн тайлан | НБХ БШУГ | Аймгийн ИТХ-ын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Ээлжит бус II хуралдааны 06 дугаар тогтоолоор “Багш” хөтөлбөрийг 3 зорилт 17 арга хэмжээ, 20 үйл ажиллагаатайгаар батлуулан хэрэгжүүлсэн. Хөтөлбөрийн 2021 оны хэрэгжилт 88.2, 2022 оны хэрэгжилт 93.3, 2023 оны хэрэгжилт 94.7 хувьтай, 2024 онд 97.8 хувьтай хэрэгжиж дууссан. |
| 11 | Хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүхий сургууль, цэцэрлэгийн барилгын тоо | тоо | 2020 | 47 | 2025 | 53 | 3 сургууль, 3 цэцэрлэг ашиглалтад орно. | 53 | Үйл ажиллагааны тайлан | НБХ БШУГ | 2021-2024 онд 4,11,18 дугаар цэцэрлэгийн өргөтгөл, Баянбулаг багийн 27 дугаар цэцэрлэг, Яргуйт багийн 28-р цэцэрлэгийн барилга, Чандмань багийн 150 хүүхдийн цэцэрлэг, 1,8 дугаар сургуулийн өргөтгөл, “Ирээдүйн одод” сургуулийн спорт заалны өргөтгөл, “Уран эгшиг” сургуулийн өргөтгөлийн барилгыг тус тус ашиглалтад оруулсан. 2025 онд Орхон политехник коллежийн хичээлийн байрны барилгын ажил дуусаж улсын комисс ажилласан, 3-р сургуулийн барилгын ажил 100% гүйцэтгэж дууссан байна. |
| 12 | Бага ангийн нэг багшид ногдох сурагчийн тоо | тоо | 2020 | 36 | 2025 | 29 | Стандартад дөхүүлнэ. | 35.4 | Боловсролын салбарын статистик мэдээ | НБХ БШУГ | 2025-2026 хичээлийн жилд 23 сургуулийн 1-5 дугаар ангийн 357 бүлэгт 12640 суралцагч суралцаж байгаа бөгөөд бага ангийн нэг багшид 35.4 хүүхэд ноогдож байна. |
| 13 | Зорилтот бүлгийн хүүхэд харах үйлчилгээний үйл ажиллагааг тогтмолжуулах, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн тоо | тоо | 2020 | 4 | 2025 | Санхүүжлтийн хэмжээгээр | - | - | 2021 оны БШУЯ-ны санхүүжилт | НБХ, БШУГ | БШУГ-аас ХГБХХГ-т шилжсэн. Аймгийн хэмжээнд СӨБ-ын 39 байгууллага байгаа нь цэцэрлэгийн хүртээмж өндөр буюу хамран сургалт 98.9% байдаг тул хүүхэд харах үйлчилгээ манай аймагт байдаггүй мөн ГБХНХЯ-аас барьж байгаа бодлого нь хилийн заставууд болон СӨБ-ын хүртээмж багатай байрлалд байгуулна гэсэн чиглэлийг баримтлан ажиллаж байна. Нийт эмэгтэйчүүдийн 48% нь хөдөлмөр эрхэлж байна. Нийт 2301 иргэн ажилд орсны 1512 нь буюу 65.7% нь эмэгтэйчүүд байна |
| Зорилт 2.2.Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэх замаар эрүүл мэндийн тусламж, | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|----|---|--------------|------|-------|------|-----------------------|---|-------|-------------------|-----|--|
| 14 | Нийгмийн дэмжлэгт хамрагдсан эрүүл мэндийн ажилтны эзлэх хувь | хувь | 2020 | 7.9 | 2025 | 20 | “Эмч” дэд хөтөлбөрийн хүрээнд, 2020 оны суурь түвшин | 16.1% | УТХ | ЭМГ | Нийт эрүүл мэндийн ажилтны 2021 онд 26%, 2022 онд 17%, 2023 онд 24.4%, 2024 онд 27.8%, 2025 онд 16.1% нь нийгмийн дэмжлэгт хамрагдсан байна. |
| 15 | Нийт үзлэгт эзлэх урьдчилсан сэргийлэх үзлэгийн хувь | хувь | 2020 | 36.2 | 2025 | 42.2 | 2020 оны суурь түвшин | 35.3% | ЭМГ статистик | ЭМГ | Нийт үзлэгт эзлэх урьдчилсан сэргийлэх үзлэг 2021 онд 39.9%, 2022 онд 33.9%, 2023 онд 34.1%, 2024 онд 33.1%, 2025 онд 35.3% нь хамрагдсан байна. |
| 16 | Алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь | хувь | 2020 | 17 | 2025 | 33 | 2020 оны суурь үзүүлэлт | 38.3% | ЗДҮАХ-ын тайлан | ЭМГ | Алсын зайн оношилгооны техник хэрэгслийн хангалтын хувь 38.3% болж зорилтот түвшинд хүрээд байна. |
| 17 | Товлолт дархлаажуулалтын хамралт | хувь | 2020 | 99.5 | 2025 | 99.5-аас бууруулахгүй | 2020 оны суурь түвшин | 99.9% | ЭМГ статистик | ЭМГ | Товлолт дархлаажуулалтын хамралт 2025 онд 99.9% болж суурь түвшинөөс 0.4 продицилээр өсчээ. |
| 18 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний | хувь | 2020 | 75 | 2025 | 85 | 2020 оны суурь түвшин | 95.6% | ЭТҮХ | ЭМГ | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшиг, онцгой байдлын үеийн хариу арга хэмжээний чадавх 95.6% болж зорилтот түвшинд хүрсэн. |
| 19 | Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь | хувь | 2020 | 88.1 | 2025 | 96 | 2020 оны суурь түвшин | 99.2% | ЭМДХ | ЭМГ | Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь 99.2%-д хүрч суурь түвшнөөс 11.1%-аар нэмэгдсэн байна.. |
| 20 | Хүн амын дундаж наслалт | жил | 2020 | 72.15 | 2025 | 73.25 | Төрөлтөөс тооцсон дундаж наслалтын хэмжээ, 2020 оны суурь түвшин | 73.66 | Аймгийн статистик | ЭМГ | Аймгийн хүн амын дундаж наслалт 73.66 болж, улсын дунджаас 1.89 жилээр өндөр байгаа ба суурь оноос 1.51 жилээр өсчээ. |
| 21 | Эхийн эндэгдлийн харьцаа (100.000 амьд төрөлтөд) | продеци миль | 2020 | 0 | 2025 | 0 | Эрт илрүүлэлт, дэвшилтэт ээлтэй шинэ технологи бүхий эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ үйлчилгээний чанар | 0 | ЭМГ статистик | ЭМГ | Тайлант хугацаанд эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. |
| 22 | Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох) | промилль | 2020 | 8.6 | 2025 | 8 | | 7.7 | ЭМГ статистик | ЭМГ | 2025 онд нялхсын эндэгдлийн 15 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7.7 промилл байгаа нь өмнөх оноос 5 тохиолдол буюу 2.2 промиллээр буурч, хүрэх түвшнөөс 0.9 промиллээр бага байна. |
| 23 | Зүрх судасны өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин (10.000 хүн амд ногдох) | продеци миль | 2020 | 15.7 | 2025 | 14.7 | | 15.9 | ЭМГ статистик | ЭМГ | Зүрх судасны өвчлөлийн шалтгаант нас баралтын түвшин 2021 онд 10000 хүн амд 21.1 промилл, 2022 онд 19.1 промилл, 2023 онд 19.9 промилл, 2024 онд 17.7 байсан бол 2025 онд зүрх судасны өвчлөлөөр нас барсан 169 тохиолдол буюу 15.9 промилл байгаа нь суурь түвшнөөс 0.2 промиллоор өссөн байна. |

| | | | | | | | | | | | |
|--|--|--------------|------|------|------|------|---|------|-----------------|--|---|
| 24 | Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин (10.000 хүн амд ногдох) | продеци миль | 2020 | 15.6 | 2025 | 13.7 | | 14.1 | ЭМГ статистик | ЭМГ | Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин 10.000 хүн амд 2021 онд 13 промилл, 2022 онд 13.5 промилл, 2023 онд 11.6 промилл, 2024 онд 15.6 промилл байсан бол 2025 онд хорт хавдрын улмаас нас барсан 150 тохиолдол буюу 14.1 промилл бүртгэгдсэн нь суурь түвшнөөс 1.5 промиллоор буурсан байна. |
| Зорилт 2.3. Гэр бүлд суурилсан хүний хөгжил, оролцоог дээшлүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж, салбар дундын уялдаа холбоог сайжруулан, залуучуудын идэвхэжсэн | | | | | | | | | | | |
| 25 | Зорилтот гэр бүлд чиглэсэн арга хэмжээнд хамрагдсан өрхийн тоо | хувь | 2020 | 20 | 2025 | 40 | Амьдралын чанарыг сайжруулсан байх, хамрагдах зорилтот гэр бүлийн тоог жил бүр 20 хувиар нэмэгдүүлнэ. | 42 | ГБХЗГ | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгаал-лын газар | 2021-2025 онд зорилтот бүлгийн гэр бүлд чиглэсэн "Гэр төсөл", "Алхам алхмаар хөтөлбөр", "Бид хамтдаа зуслан хөтөлбөр", эрсдэлт бүлгийн гэр бүлүүдэд сэтгэл заслын үйлчилгээ хөтөлбөр, "Сайн уу үр минь", "Хосын болзоо" өдөрлөг, эрүүл мэнд, хууль хяналтын байгууллагад холбон зуучлах үйлчилгээ, амьдрах ухааны сургалт, нөлөөллийн олон талт арга хэмжээнд давхардсан тоогоор 7934 иргэн буюу 3362 өрх хамрагдсанаар зорилтот гэр бүлийн 42 хувийг хамруулсан. |
| 26 | Гэр бүл цуцлалт, 1000 хүн амд ногдох | тоо | 2020 | 1.4 | 2025 | 0.5 | Гэр бүл цуцлалтыг багасгана. | 1.8 | Статистик мэдээ | ХГБХХГ, УБХ | Гэр бүл цуцлалт 2022 оноос өсч 200-д хүрсэн ба 2023 онд 229, 2024 онд 212 бүртгэгдсэн бол гэр бүлд чиглэсэн нөлөөллийн ажлын үр дүнд 2025 онд 192 бүртгэгдэж өмнөх оноос 9.5 хувиар буурсан байна. Ингэснээр 1000 хүн амд ногдох гэр бүл цуцлалт 1.8 байна. |
| 27 | Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг | тоо | 2020 | 27 | 2025 | 18 | Гэр бүлийн хүчирхийллийн хэргийг бууруулна. | 59 | ГБХЗГ | ХГБХХГ | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2021 онд 31, 2022 онд 32, 2023 онд 35, 2024 онд 66 бүртгэгдсэн бол 2025 онд 59 бүртгэгдэж өмнөх оноос 10.6 хувиар буурсан байна. |
| 28 | Хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | тоо | 2020 | 640 | 2025 | 736 | Жил бүр 3 хувиар нэмэгдүүлнэ. | 2430 | ГБХЗГ | ХГБХХГ | Аймгаас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 268.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Үйл ажиллагаанд нийт 2430 иргэн хамрагдсанаас 1339 хүүхэд, 1903 насанд хүрэгч, 515 гэр бүлийг хамруулан ажилласан байна. |

| | | | | | | | | | | | |
|--|---|-----|------|------|------|-------|---|-------|--------------|---------------|---|
| 29 | Хүүхдийн хүмүүжил төлөвшил, гэр бүлийн боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан эцэг, эхчүүдийн тоо | тоо | 2020 | 8950 | 2025 | 17900 | Нөлөөллийн ажилд хамрагдсан эцэг эхчүүдийг жил бүр 20 хувиар нэмэгдүүлнэ. | 37460 | ГБХЗГ | ХГБХХГ | Гэр бүлийн гишүүдийн хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, хүн амын бүлгүүд эмэгтэйчүүд залуучуудад чиглэсэн нөлөөллийн аян, өдөрлөг, хувь хүний хөгжлийн сургалт, сэтгэлзүйн зөвлөгөө, бүлгийн уулзалт зэрэг 78 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 37460 иргэн хамруулж, өмнөх онтой харьцуулахад 24.3 хувиар нэмэгдсэн. |
| 30 | Залуучууд хөгжлийн төв, Залуучуудын ордноор үйлчлүүлсэн залуучуудын тоо | тоо | 2020 | 5980 | 2025 | 12000 | Залуучуудын тоог жил бүр 20 хувиар нэмэгдүүлнэ. | 12525 | ГБХЗГ | ХГБХХГ | Залуучуудын ордноор үйлчлүүлсэн залуучуудын тоо 2021 онд 6957, 2022 онд 16000, 2023 онд 17760, 2024 онд 10560, 2025 онд давхардсан тоогоор 12525 залуучуудыг хамруулсан нь нийт залуучуудын 47.5 хувьд хүрч ажилласан байна. |
| Зорилт 2.4. Шинжлэх ухаан, технологийг аймаг, хотын тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай инновацыг хөгжүүлнэ. | | | | | | | | | | | |
| 31 | Эрдэнэт Шинжлэх Ухаан, Технологийн Паркийн санаачлан хэрэгжүүлсэн төслийн тоо | тоо | 2019 | 10 | 2025 | 45 | 2019 оны суурь түвшин | 37 | Эрдэнэт ШУТП | ХБТХОХ, ЭШУТП | “Гарааны бизнес-2023” төслийн хүрээнд 33 өрхийн болон бичил үйлдвэрлэл эрхлэгчид тус бүр 5.0, хүнсний болон ногоон сууцны үйлдвэрлэлийн 3 төсөлд тус бүр 35.0, нийт 270.0 сая төгрөгийг эргэн төлөх нөхцөлтэйгээр олгосон. Хүүхэд залуучуудад программ, код хөгжүүлэх сургалт явуулж буй “Код лаб” сургалтын төвд орон нутгийн төсвөөс 33.0 сая төгрөгийн өртөг бүхий 12 ширхэг зөөврийн компьютер олгосон. Тус сургалтын төвөөс 62 сурагчийг программ, код хөгжүүлэх сургалтанд хамруулж чадавжуулсан. |
| 32 | Их дээд сургууль, МСҮТ, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг хамруулсан гарааны бизнес эрхлэгчдийн тоо | тоо | 2020 | 5 | 2025 | 25 | 2020 оны суурь түвшин | 17 | Эрдэнэт ШУТП | ХБТХОХ, ЭШУТП | 2021-2023 онд ЭЦДС ТӨХК-ийн багш, оюутны хамтарсан 10 гарааны бизнест хөрөнгө оруулалтын дэмжлэг, сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. 2024 онд Орхон политехникийн коллежтой хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан оёдлын чиглэлээр 2 гарааны бизнес хөгжүүлэхэд зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлсэн. Мөн залуу багш, төслийн багийн гишүүдэд сургалт орж 5 гарааны бизнес хөгжүүлэх үе шаттай зөвлөх үйлчилгээ үзүүлсэн. |

| | | | | | | | | | | | |
|---|---|------|------|------|------|-------|---|-------|-----------------|--------------------|--|
| 33 | Үйлдвэрлэл технологийн болон ШУТПаркийн ногоон технологийн тоо | тоо | 2019 | 1 | 2025 | 12 | 2019 оны суурь түвшин | 10 | Эрдэнэт ШУТП | ХБТХОХ, ЭШУТП | Бойжуулсан ногоон технологийн тоо 10 |
| 34 | Аймгийн нийт өрхийн интернэтэд холбогдсон өрхийн эзлэх хувь | хувь | 2019 | 37.6 | 2025 | 70 | 2019 оны суурь түвшин | 79.8 | Статистик мэдээ | ХБТХОХ, МХГ | Интернэтэд холбогдсон өрхийн тоо 20.9 мянгад хүрч суурь оноос нийт өрхөд эзлэх хувь 42.2 хувиар нэмэгдэж 79.8 хувьд хүрчээ. |
| Зорилт 2.5. Эрүүл, аюулгүй, баталгаат орчныг бий болгоно. | | | | | | | | | | | |
| 35 | Байгальд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй ногоон барилга байгууламжийг нэмэгдүүлсэн айл өрх | тоо | 2020 | 5 | 2025 | 200 | Сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан өрхийн тоо | 482 | ХЗА | ХЗА, ХБТХОХ, ХББЗА | Нийт 458 өрх сэргээгдэх эрчим хүчээр цахилгаанаа шийдсэн байгаа ба 98%-нь малчин өрх байна. Баян-Өндөр суманд Малчин багаас бусад багт 9 өрх цахилгаанаа сэргээгдэх эрчим хүчээр шийджээ. Цагаанчулуут, Рашаант багийн 19 м.кв хүртэлх талбай бүхий монгол гэртэй 24 айл өрхийн гэрийн дулаалга, халаалт, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн иж бүрэн багцыг олгох, хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцож, баталгаажуулах төслийг хэрэгжүүлсэн. |
| | | тоо | 2020 | 150 | 2025 | 1000 | Цахилгаан халаалттай өрхийн тоо | 854 | ХЗА | ХЗА, ХБТХОХ, ХББЗА | Сүүлийн жилүүдэд цахилгааны найдвартай байдлыг хангах чиглэлээр томоохон хөрөнгө оруулалт хийснээр айл өрхүүд цахилгаан халаалтад холбогдох нөхцөл бүрдсэн. Мөн 2024 онд Баян-Өндөр сумаас урамшуулал олгох бодлого хэрэгжүүлснээр халаалтаа цахилгаанаар шийдвэрлэсэн гэр хорооллын айл өрх 854-д хүрээд байна. |
| | | тоо | 2020 | 2560 | 2025 | 24100 | 2 тарифт тоолууртай өрхийн тоо | 26547 | ХЗА | ХЗА, ХБТХОХ, ХББЗА | Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг 2 тарифт ухаалаг тоолуурт шилжүүлэх ажлын хүрээнд нийт 26547 тоолуурыг бүрэн суурилуулж дуусган холболтын ажил хийгдсэн. |

| | | | | | | | | | | | |
|----|--|------|------|-----|------|------------------|---|------|-----|--------------|--|
| 36 | Борооны усны суваг, үерийн далангийн урт | Км | 2020 | 9.8 | 2025 | Төслийн хэмжээнд | Үерийн усны шороон суваг 72.8 км, усны шугам 420 км | 13.8 | ХЗА | ХЗА, ХБТХОХ | 2025 онд 2400 м үерийн суваг шинээр хийж нийт гэр хороололд 13.8 км үерийн хамгаалалтын инженерийн хийцлэлтэй далантай боллоо. ЕСБХБ-ны 14.0 сая.ам.долларын санхүүжилтээр “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төсөл хэрэгжиж байна. Энэхүү ажлын хүрээнд нийт 8 байршилд 12.8 км урттай үерийн хамгаалалтын далан барих ажил хийгдэнэ. Ажлын гүйцэтгэл 60 хувьтай байна. |
| 37 | Орон нутгийн хүнс үйлдвэрлэгчдийн хүнсний аюулгүй байдлыг хангасан бүтээгдэхүүний эзлэх хувь | хувь | 2020 | 70 | 2025 | 85 | 2020 оны суурь түвшин | 85.6 | ХЗА | ХБТХОХ, СХЗХ | 221 хүнсний чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгосноор нийт 43 аж ахуйн нэгж, иргэний /46.7 хувь/ бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 448 /93.0 хувь/ хүнсний чиглэлийн үйлчилгээ нийт 85.6% нь тохирлын баталгаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байна. |

Гурав. Амьдралын чанар ба дундаж давхарга

Зорилго 3. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, орон сууцанд амьдрах боломжийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг тэлэн амьдралын чанарыг

Зорилт 3.1. Ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

| | | | | | | | | | | | |
|----|----------------------------------|------|------|----|------|-----|------------------------------------|-----|--------------------|-----|---------------------------------------|
| 38 | "Ач санах" хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2020 | 90 | 2025 | 100 | Хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн байна. | 100 | Хөтөлбөрийн тайлан | НБХ | "Ач санах" хөтөлбөрийн хэрэгжилт 100% |
| 39 | "Анхдагч" хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2020 | 90 | 2025 | 100 | Хөтөлбөр 100 хувь хэрэгжсэн байна. | 100 | Хөтөлбөрийн тайлан | НБХ | "Анхдагч" хөтөлбөрийн хэрэгжилт 100% |

Зорилт 3.2. Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт хүргэж, ил тод, нээлттэй байдлыг хангана.

| | | | | | | | | | | | |
|----|--|------|------|-----|------|-----|---|------|----------------|------|--|
| 40 | Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар авч буй иргэдийн эзлэх хувь | хувь | 2020 | 10 | 2025 | 100 | 2020 оны суурь түвшин, хүрэх түвшин тухайн жилд хуваарилагдах хөрөнгөөс хамаарна. | 100 | ХХҮГ-ын тайлан | ХХҮГ | Нийгмийн халамжийн үйлчилгээг ehalamj.mn цахим системд үе шаттайгаар шилжүүлснээр шилжиж эхэлсэн. 2020 онд 6, 2021 онд 26, 2022 онд 40 төрлийн үйлчилгээг цахимд шилжүүлж, 2023 оноос нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ 100% цахимжсаны үр дүнд иргэд нийгмийн халамжийн үйлчилгээнд цахимаар хамрагдаж, өргөдөл хүсэлтээ гаргаж байна. |
| 41 | Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлд мөнгөн тусламж, ОНОТХУ-д хамрагдсан иргэдийн тоо | тоо | 2020 | 430 | 2025 | 500 | 2020 оны суурь түвшин, хүрэх түвшин тухайн жилд хуваарилагдах хөрөнгөөс хамаарна. | 1930 | ХХҮГ-ын мэдээ | ХХҮГ | 2020-2025 онд онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд орон нутгийн төсвөөс 736.3 сая төгрөг зарцуулж 1930 хүн хамрагдсан. |

Зорилт 3.3. Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах бодлогыг дэмжинэ.

| | | | | | | | | | | | |
|---|--|------|------|------|------|------|--------------------------|------|------------------|----------------|--|
| 42 | Орон сууцаар хангагдсан өрхийн тоо | тоо | - | - | 2025 | 500 | 2021 оноос шинээр тооцох | 3529 | ЗДҮАХ-ын тайлан | ГХБХБГ, ХБТХОХ | Аймгийн хэмжээнд орон нутгийн хөрөнгө оруулалтаар дундаж орлоготой өрхүүдэд зориулан түрээслэх болон өмчлөх хэлбэрээр Уртын гол багт 5 блок бүхий 260 айлын орон сууцны барилгын ажлыг 2022 оноос эхлүүлсэн. Тус барилгын төсөвт өртөг 27.4 тэрбум төгрөгөөс 19.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгон ажилласнаар одоогийн байдлаар эхний 4 блок барилгыг хүлээн авч, иргэдийг оруулах ажлыг зохион байгуулснаар 17 иргэн түрээсээр, 184 иргэн худалдан авч нийт 201 айл тус орон сууцанд ороод байна. 2021-2025 онд аймгийн хэмжээнд нийтийн орон сууцны 47 блокын 3529 орон сууц ашиглалтад орсон байна. |
| Зорилт 3.4 Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагаанд үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн, ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга | | | | | | | | | | | |
| 43 | Ядуурлын хамралтын хүрээ | хувь | 2019 | 23.5 | 2024 | 10 | 2019 оны суурь түвшин | 23.7 | Статистик мэдээ | СХ | Ядуурлын хамралтын хүрээний судалгаа 2022 онд хийгдсэн дүнгээр 23.7% байна. |
| 44 | Ажилгүйдлийн түвшин | хувь | 2019 | 22.4 | 2024 | 4.5 | 2019 оны суурь түвшин | 7.4 | Статистик мэдээ | СХ | Ажилгүйдлийн түвшин 2024 онд 7.4%-д хүрсэн. |
| 45 | Шинээр бий болсон ажлын байр | тоо | 2020 | 1400 | 2025 | 1400 | 2020 оны суурь түвшин | 1052 | Статистик мэдээ | ХХҮГ, СХ | Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн санд 2021 онд 1026, 2022 онд 969, 2023 онд 1100, 2024 онд 1104, 2025 онд 1052 шинэ ажлын байрыг бүртгэсэн. |
| 46 | "Эрдэнэтчүүд эрдэнэтчүүддээ хайртай" хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2020 | - | 2025 | 100 | 2020 оны суурь түвшин | 90 | ЗДҮАХ-ийн тайлан | ХХҮГ | Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд аймгийн ЗДТГ, Эрдэнэт ШУТП хамтран орон нутгийн төсвийн 810 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг 112 төсөлд эргэн төлөгдөх нөхцлөөр олгож хөтөлбөр 90 хувьтай хэрэгжсэн. Төслүүд нь оёдол, гар урлал 20, газар тариалан 5, хүнсний үйлдвэрлэл 24, металл хийц 3, модон хийц 10, мал, амьтны аж ахуй 4, хог хаягдал дахин боловсруулах 11, үйлчилгээ 17, бусад 18 салбар байна. Бизнес эрхлэгчдийн төслийн хэрэгжилт 80 хувь, шинээр бий болон ажлын байрны тоо 250, хадгалагдсан ажлын байрны тоо 135, шинээр бий болсон бүтээгдэхүүний тоо 87 байна. |

| | | | | | | | | | | | |
|--|---|-----|------|------|------|------|------------------------|------|----------------|------|---|
| 47 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | тоо | 2020 | 1520 | 2025 | 1720 | 2020 оны суурь түвшин, | 2204 | ХХҮГ-ын тайлан | ХХҮГ | Хөдөлмөр эрхлэлтийн чадварын үнэлгээнд 739 иргэн, хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөөг 438 иргэн, ажил мэргэжлийн чиг баримжаа зөвлөгөө мэдээллийн ганцаарчилсан үйлчилгээнд 150 иргэн, бүлгийн зөвлөгөө мэдээлэл 525 нийт 1414 иргэн хамрагдсан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ЕБС-н ахлах 10, 11 -р ангийн 725 сурагчдийг Эрдэнэт үйлдвэртэй танилцах, мэргэжил сурталчилах аялал зохион байгуулагдсан. Орхон аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Боловсролын газартай хамтран хэрэгжүүлж буй “Миний мэргэжил-Миний ажил” төслийн хүрээнд Эрдэнэт цогцолбор дээд сургуультай хамтран инженер мэргэжил сонгосон 65 суралцагчийг сонгосон мэргэжилтэй нь танилцуулсан. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагааны хүрээнд мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлэх цуврал сургалтыг ЕБС-иудын 8-12 дугаар ангийн сурагчид болон түүний эцэг, эх асран хамгаалагч нарт 72 удаа зохион байгуулж нийт 3727 иргэн хамрагдсан байна. |
| 48 | Ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоо | тоо | 2020 | 1000 | 2025 | 1000 | 2020 оны суурь түвшин | 1127 | ХХҮГ-ын тайлан | ХХҮГ | 2021 онд 1006, 2022 онд 920, 2023 онд 1050, 2024 онд 1005 иргэд ажилд зуучлагдсан байна. 2025 онд 340 ажил олгогч болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдээс 1878 ажлын байрны захиалга бүртгэж 1127 иргэнийг ажилд зуучилсан. |
| 49 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн тоо | тоо | 2020 | 53 | 2025 | 90 | 2020 оны суурь түвшин | 86 | ХХҮГ-ын тайлан | ХХҮГ | 2021 онд 56, 2022 онд 87, 2023 онд 101, 2024 онд 110, 2025 онд 86 иргэнд санхүүгийн дэмжлэгийг олгосон ба 2021-2025 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт, ажлын байр дэмжих, малжуулах, ахмадын хөдөлмөр эрхлэлт, залуучуудын хөдөлмөр эрхлэлт зэрэг 5 хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт нийт 542 иргэний төсөлд 2.6 тэрбум төгрөгийг 24-48 сарын хугацаатай хүүгүй барьцаагүй олгож 645 байнгын ажлын байр бий болсон. |
| Зорилт 3.5. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын зөв хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, спортоор хичээллэх ээлтэй орчныг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|------|------|-------|------|-------|---|-------|--------------------|--------|---|
| 50 | Спортын магадлан итгэмжлэлд хамрагдах спортын клуб, фитнес клубийн тоо | тоо | 2020 | 3 | 2025 | 6 | Стандарт хангасан клубын тоог нэмэгдүүлнэ. | 3 | ЗДҮАХ-ийн тайлан | БТСГ | 2025 онд 15 фитнес клубт 2210 иргэн тогтмол хичээллэж байна. Эдгээр фитнес клубүүдээс 3 клуб нь Магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд эрхээ авсан боловч фитнес клубээр үйлчлүүлсэн иргэдэд эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагаа улсын хэмжээнд 2021 оноос хойш хийгдээгүй. |
| 51 | Биеийн тамир, спортоор хичээллэх заал талбай | тоо | 2020 | 33 | 2025 | 37 | Жил бүр 1 талбай нэмэгдсэн байна. | 38 | ЗДҮАХ-ийн тайлан | БТСГ | Аймгийн хэмжээнд төрийн өмчит байгууллагууд болон хувийн хэвшил, ерөнхий боловсролын сургуулиудад нийт 38 спорт заал ашиглагдаж байна. Ингэснээр аймгийн хэмжээнд 1 хүнд ногдох спорт заалны хүртээмжийн индекс 0.166м2 болсон байна. |
| 52 | Өвлийн спортын дэд хөтөлбөрийн хэрэгжилт | хувь | 2020 | 10 | 2025 | 100 | Хичээллэгсдийн тоог 40 хувиар нэмэгдүүлсэн байна. | 92.5% | Хөтөлбөрийн тайлан | БТСГ | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр"-ийн биелэлт 2021 онд 76 хувь, 2022 онд 86.5 хувь, 2023 онд 92.5 хувтай хэрэгжиж дууссан. 2024 оноос өвлийн спортын хөтөлбөрийг төсөл арга хэмжээ болгон үргэлжлүүлж "Эрдэнэт мөнгөн өвөл" аяныг 4 дэх жилдээ зохион байгуулсан. |
| 53 | Спортын хэрэгслийн /ердийн болон цахилгаан дугуй, цана, тэшүүр, дугуйт цана, дугуйт тэшүүр/ түрээсийн үйлчилгээ | тоо | 2020 | - | 2025 | 4 | Спортын хэрэгслийн түрээсийн үйлчилгээ нэвтэрсэн байна. | 4 | ЗДҮАХ-ийн тайлан | БТСГ | 2025 онд 4 байршилд 4 иргэн, аж ахуйн нэгж уулын цана, чарга, тэшүүр, гэр бүлийн дугуй, дугуйн түрээсийн үйлчилгээг 4200 гаруй хүүхэд залууст үзүүлсэн. |
| Зорилт 3.6. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн, хүн амыг эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | |
| 54 | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө | га | 2020 | 84517 | 2025 | 84517 | Хэрэгжилт 100 хувьд хүрсэн байна. | 84517 | ҮЧ-ын хэрэгжилт | ГХБХБГ | Аймгийн Газар зохион байгуулалтын 2022-2037 оны ерөнхий төлөвлөгөөг "Ланд овнер" ХХК - аар гүйцэтгүүлж аймгийн ИТХ-ын 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 12/03 тогтоолоор батлуулсан. 2025 оны байдлаар 84517га-д хэрэгжүүлэх Аймгийн газар зохион байгуулалтын 2022-2037 оны төлөвлөгөөний хэрэгжилт 40 хувийн хэрэгжилттэй байна. |

| | | | | | | | | | | | |
|----|--|-----|------|-----|------|-----|--|-----|--------|---------------------|---|
| 55 | Геодезийн сүлжээг шинэчлэн сайжруулж, аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байр зүйн зураг хийсэн цэгийн тоо | цэг | 2020 | 116 | 2025 | 126 | Геодезийн сүлжээ шинэчлэн сайжирсан байна. | 202 | ГХБХБГ | ГХБХБГ, Сумдын ЗДТГ | 2021 онд нэмж байр зүйн зураг хийсэн цэгийн тоо нэмэгдээгүй, 2022 онд 33 геодезийн цэгийг шинээр суулгаж улсын нэгдсэн санд хүлээлгэн өгсөн. 2023 оны геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж шинээр 16 геодезийн цэг нэмж байгуулах ажлыг хүлээн авсан. 2024 оны геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж аймгийн хэмжээнд улсын нэгдсэн систем болох геопортал цахим системд геодезийн 163 цэг, тэмдэгт бүртгэлтэй байна. 2025 онд аймагт бүртгэлтэй цэгүүдээс тооллогын үр дүнд хөрсний репер Rp77 дугаартай цэг нь Булган аймаг, Сэлэнгэ сумын нутаг дэвсгэрт, Rp73 дугаартай цэг нь Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт харьяалагдаж аймгийн хилийн цэсээс гарсан тул дээрх 2 цэгийг геодезийн цэг тэмдэгтийн тооллогоос хассан, шинээр 37 цэг тэмдэгтийн хувийн хэргийг төрийн хамгаалалтад хүлээлгэн өгсөн. Ингэснээр аймгийн хэмжээнд улсын нэгдсэн систем болох геопортал цахим системд геодезийн 202 цэг, тэмдэгт бүртгэгдлээ. |
|----|--|-----|------|-----|------|-----|--|-----|--------|---------------------|---|

Дөрөв. Эдийн засаг

Зорилго 4. Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, олон тулгуурт эдийн засагтай хот болно.

Зорилт 4.1. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

| | | | | | | | | | | | |
|----|----------------------------|---------------|------|--------|------|--------|-----------------------|--------|-----------------|------------|--|
| 56 | Эдийн засгийн дундаж өсөлт | хувь | 2019 | 1.8 | 2024 | 6.6 | Суурь түвшин (2016) | 18% | Статистик мэдээ | СХ, ХБТХОХ | Эдийн засгийн салбарын ДНБ нь 2021 онд 74.5%-аар, 2022 онд 6.2%-иар, 2023 онд 3.9%-аар өссөн бол 2024 онд 2.9 буурчээ. 2025 онд аймгийн эдийн засгийн голлох салбар болох аж үйлдвэрийн салбарын борлуулалт 18.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. |
| 57 | Нэг хүнд ногдох ДНБ | мянган төгрөг | 2019 | 10,684 | 2024 | 23,265 | 2019 оны суурь түвшин | 33,843 | Статистик мэдээ | СХ, ХБТХОХ | Нэг хүнд ногдох ДНБ 2021 онд 64.8%-аар, 2022 онд 9.2%-аар, 2023 онд 6.8%-аар, 2024 онд 33.8 сая болж суурь түвшнөөс 66.7%-аар нэмэгджээ. |

| | | | | | | | | | | | |
|---|--|------|------|------|------|------|-----------------------|------|-----------------|---------------------|--|
